**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2023/94/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.bulgan@audit.gov.mn<br>Булган аймаг Булган сум<br>2023 он | Булган аймаг дахь ТАГ-н дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас:89009802 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 99057478 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn<br>Ахлах аудитор:<br>Утас: Цахим хаяг:<br>Аудитор: Б.Золжаргал<br>Утас: 90119931 Цахим хаяг: zoljargalb@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........................................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга......................................................................................................
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.......................................................................................
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .......................................................................................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..............................................................................
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....................................
4. Аудитын тайлан ....................................................................................................................................
4.1 Ерөнхий зүйл ........................................................................................................................
4.2 Материаллаг байдал ...............................................................................................................
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....................................................................................
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...................................
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................................
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....................................................................................
5. Аудитын илрүүлэлт ...............................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....................................................................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**БУЛГАН АЙМГИЙН**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 111

танай ______________ ны № ______________ т

БУЛГАН СУМЫН ХОЁРДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хоёрдугаар цэцэрлэг нь 2022 онд улсын төсвөөс 594,592.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 116,240.5 мянган төгрөгийн санхүүжилт авч ажиллажээ.

Булган сумын Засаг даргатай хийсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 100% биелэлттэй гэж үнэлэгджээ.

D:/bichighereg/2022A4toot

006020117

**Аудитын гол асуудал**

Хоёрдугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/35 тоот албан бичгийн дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийсэн төлөвлөгөөт бус хяналтаар 239.6 мянган төгрөгийн хүүхдийн хоолны материал илүүдэлтэй байсныг бүртгэх, 2,194.4 мянган төгрөгийн дутагдуулсан хөрөнгөнд төлбөрийн акт тогтоосныг буруутай албан тушаалтнаар төлж барагдуулж хэрэгжилтийг тайлагнасан.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

D:/bichighereg/2022A4toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **59,425,596.88** | **82,550,195.01** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 11,592,131.40 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 11,592,131.40 |
| **3121** | **Төгрөг** | - | 11,592,131.40 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 11,592,131.40 |
| **33** | **АВЛАГА** | 1,863,400.00 | 110,535.93 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 110,535.93 |
| **335** | **Бусад авлага** | 1,863,400.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,863,400.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 57,562,196.88 | 70,847,527.68 |
| **351** | **Түүхий эд материал** | 140,240.00 | 43,705.00 |
| 35130 | Эм боох материал | 140,240.00 | 43,705.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 57,421,956.88 | 70,803,822.68 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,191,500.00 | 1,442,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,016,312.88 | 15,992,977.68 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,154,900.00 | 1,154,900.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 8,500.00 | 8,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,452,726.50 | 12,878,927.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 36,598,017.50 | 39,326,017.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,349,763,051.40** | **1,318,925,238.80** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,349,763,051.40 | 1,318,925,238.80 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,312,936,801.58 | 1,282,628,989.02 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,340,263,493.00 | 1,340,263,493.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (80,784,563.28) | (103,122,288.12) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 53,610,641.00 | 46,481,141.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (22,869,865.76) | (25,610,491.12) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 42,255,314.00 | 40,018,967.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (21,491,746.24) | (17,033,728.84) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,987,750.00 | 2,987,750.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,344,487.14) | (1,666,119.90) |
| 39217 | Ном | 310,266.00 | 310,266.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 36,826,249.82 | 36,296,249.78 |
| 39301 | Програм хангамж | 2,380,000.00 | 2,380,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (723,750.18) | (1,253,750.22) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 35,170,000.00 | 35,170,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,409,188,648.28** | **1,401,475,433.81** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **6,126,140.13** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 6,126,140.13 |
| **413** | **Өглөг** | - | 6,126,140.13 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 59,350.73 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 6,066,789.40 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,409,188,648.28** | **1,395,349,293.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,409,188,648.28 | 1,395,349,293.68 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 241,344,798.00 | 241,344,798.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 241,344,798.00 | 241,344,798.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 941,716,271.76 | 927,876,917.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 941,716,271.76 | 941,716,271.76 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (13,839,354.60) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 226,127,578.52 | 226,127,578.52 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,409,188,648.28** | **1,401,475,433.81** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **-** | **720,241,160.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **9,407,760.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 9,407,760.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 8,589,000.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 8,589,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 715,260.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 103,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **710,833,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 594,592,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 594,592,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 116,240,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 116,240,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **734,080,514.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **734,080,514.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 725,155,340.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 448,523,177.56 |
| 210101 | Үндсэн цалин | - | 327,381,424.80 |
| 210102 | Нэмэгдэл | - | 92,285,129.00 |
| 210104 | Урамшуулал | - | 28,856,623.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 57,918,471.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 39,596,572.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 4,643,482.05 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 3,691,635.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 899,525.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 9,087,256.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 95,923,889.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 9,094,464.00 |
| 210302 | Түлш, халаалт | - | 78,087,260.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 8,742,164.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 4,863,485.20 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 483,400.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 4,380,085.20 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 60,430,294.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 96,535.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 60,333,759.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 180,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 180,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 1,227,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,227,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 56,088,222.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 12,837,760.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 3,823,650.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | - | 39,426,812.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 8,925,174.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 8,925,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 8,925,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 174.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 174.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-** | **(13,839,354.60)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-** | **(13,839,354.60)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **-** | **710,833,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **710,833,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 594,592,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 594,592,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 116,240,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 116,240,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **-** | **699,241,268.60** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **699,241,268.60** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **690,316,094.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | 448,574,362.76 |
| 210101 | Үндсэн цалин | - | 327,432,610.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 92,285,129.00 |
| 210104 | Урамшуулал | - | 28,856,623.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | 57,918,471.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 39,596,572.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 4,643,482.05 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 3,691,635.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 899,525.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 9,087,256.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 89,857,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 9,094,464.00 |
| 210302 | Түлш, халаалт | - | 72,020,471.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 8,742,164.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 483,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 483,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 69,054,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 69,054,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 1,227,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,227,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 22,200,260.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 15,420,260.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 6,780,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **8,925,174.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 8,925,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 8,925,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 174.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 174.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **11,592,131.40** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 11,592,131.40 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 11,592,131.40 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | - | - | - | | - |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **-** | **-** | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 241,344,798.00 | 226,127,578.52 | 941,716,271.76 | | 1,409,188,648.28 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **241,344,798.00** | **226,127,578.52** | **941,716,271.76** | **-** | 1,409,188,648.28 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **241,344,798.00** | **226,127,578.52** | **941,716,271.76** | **-** | 1,409,188,648.28 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **241,344,798.00** | **226,127,578.52** | **941,716,271.76** | **-** | 1,409,188,648.28 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,  бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (13,839,354.60) | | (13,839,354.60) |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **241,344,798.00** | **226,127,578.52** | **927,876,917.16** | **-** | 1,395,349,293.68 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 714,555,000.00 | 699,241,094.60 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 714,555,000.00 | 699,241,094.60 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 705,630,000.00 | 690,316,094.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 455,868,000.00 | 448,574,362.76 |
| 210101 | Үндсэн цалин | 374,004,200.00 | 327,432,610.00 |
| 210102 | Нэмэгдэл | 69,079,200.00 | 92,285,129.00 |
| 210104 | Урамшуулал | 12,784,600.00 | 28,856,623.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,647,600.00 | 57,918,471.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,176,000.00 | 39,596,572.70 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,117,800.00 | 4,643,482.05 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,094,900.00 | 3,691,635.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,023,200.00 | 899,525.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,235,700.00 | 9,087,256.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 89,857,100.00 | 89,857,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,800,000.00 | 9,094,464.00 |
| 210302 | Түлш, халаалт | 74,057,100.00 | 72,020,471.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,000,000.00 | 8,742,164.60 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 483,400.00 | 483,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 483,400.00 | 483,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 69,056,500.00 | 69,054,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 69,056,500.00 | 69,054,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,516,000.00 | 1,227,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,258,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,258,000.00 | 1,227,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,201,400.00 | 22,200,260.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,421,400.00 | 15,420,260.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,780,000.00 | 6,780,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,925,000.00 | 8,925,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,925,000.00 | 8,925,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,925,000.00 | 8,925,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 710,833,400.00 | 710,833,400.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 594,592,900.00 | 594,592,900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 594,592,900.00 | 594,592,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 116,240,500.00 | 116,240,500.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 116,240,500.00 | 116,240,500.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **11,592,131.40** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган сумын Хоёрдугаар цэцэрлэг нь 2022-2023 оны хичээлийн жилд

- Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, 5 настай хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургуульд суралцах бэлтгэлийг хангах;
- Хүүхэд бүр сургалтын байгууллагын орчинд айдасгүй, амар тайван суралцах, аливаа хэлбэрийн гадуурхал, дарамт, дээрэлхэхээс ангид тэгш, хүртээмжтэй, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд талуудын идэвхтэй хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлэх
- Сургалтын байгууллагын үйл ажиллагааны үр дүн, багшийн ажлын гүйцэтгэлд суурилан байгууллага болон багшийн хөгжлийн дэмжих уян хатан, олон хэлбэрт сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил, байгууллагын үйлчилгээний чанарт ахиц гаргах;
- Боловсролын байгууллагын багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг эрхэмлэн баг, хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлэх санал санаачилгыг дэмжих, манлайлах, үр дүнг тооцох;
- Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх зохистой дадал хэвшилд сургах, сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах;
- Цэцэрлэг, сургуулийн нэг хүүхдэд улсын төсвөөс олгох хувьсах зардлын санхүүжилтийг зориулалтын дагуу хамт олны оролцоотой төлөвлөж, хэрэгжилтийг үр дүнтэй, ил тод, нээлттэй хангах;
- Сургалтын байгууллага хоорондын хамтран ажиллах чадавхыг бэхжүүлж, цэцэрлэг, сургуульд суурилсан менежментийг сайжруулахад мэргэжлийн холбоо, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг зорилт тавин ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль зэрэг бусад эрх зүйн акт, тогтоомжуудыг мөрдөж ажилладаг

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккуруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан "Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажилладаг. Үйл ажиллагаанд нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,713.2 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 11,592.1 | 11,592.1 |
| Авлага | 1,863.4 | 110.5 | -1,752.9 |
| Бараа материал | 57,562.2 | 70,847.5 | 13,285.3 |
| Үндсэн хөрөнгө | 1,349,763.1 | 1,318,925.2 | -30,837.1 |
| **Нийт хөрөнгө** | **1,409,188.6** | **1,401,475.4** | **-7,713.2** |
| Өр төлбөр | 0.00 | 6,126.1 | -6,126.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,409,188.6 | 1,395,349.2 | -13,839.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,409,188.6** | **1,401,475.4** | **-7,713.2** |

Дээрх хүснэгтээс харахад:

- ✓ Авлага өмнөх оны үлдэгдлээс 1,863.4 мянган төгрөгөөр төлөгдөж, тайлант онд ХХОАТ-н зөрүү тооцоогүйгээс үүссэн 110.5 мянган төгрөгийн авлага байна.
- ✓ ХХОАТ өглөг 59.3 мянга, түлш халаалтын өглөг 6,066.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.
- ✓ Үндсэн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 30,837.1 мянган төгрөгөөр буурсан нь акталж устгасан 8,575.8 мянга, элэгдлийн зардал зэрэг нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төслийг 795,073.3 мянган төгрөгөөр төлөвлөж хүргүүлсэн.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг сумын ИТХ-ын 2022 оны 8-р хуралдааны 21-р тогтоолоор 710,833.4 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 1700.0 | 1,700.0 | 0.0 | 100% |
| 2 | 81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 69,056.5 | 69,054.7 | 1.8 | 99.9% |
| 3 | 81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх | 1,700.0 | 1,700.0 | 0.0 | 100% |
| 4 | 81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 453,168.8 | 448,120.9 | 5,047.9 | 98.8% |
| 5 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хэвийн хангах | 67,032.0 | 60,489.5 | 6,542.5 | 90.2% |
| 6 | 81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх | 1,935.6 | 1,935.6 | 0.0 | 100% |
| 7 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 90,857.1 | 90,857.1 | 0.0 | 100% |
| 8 | 80112-нийтлэг үйлчилгээ | 25,383.4 | 25,383.2 | 0.2 | 99.9% |
| | **Дүн** | **710,833.4** | **699,241.2** | **11,592.2** | **98.3%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тус ойн анги нь нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122 тоот тушаалын 2-д заасны дагуу 2022 оны 1.2 дугаар сард ТҮБД зэрэглэлийн 5 дугаар шатлалаар цалинжиж байсан багш нарын цалинг тооцохдоо 1 багшийн цалинг тооцолгүй үлдээснийг нөхөж олгох зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь ТАГ-н аудитор Б.Золжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Хоёрдугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь ТАГ-т 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардал 734,181.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,012.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 8,259.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 31 асуудал сонгогдсоноос илэрсэн зөрчилгүй, хэрэгжүүлж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тендерт шалгаруулсан худалдан авах ажиллагааны талаарх 1 удаагийн 69,056,500.0 төгрөгийн мэдээ мэдээлэхийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 38 удаагийн 695,530,760.0 төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлэхээс 7 удаагийн 178,686,200.0 төгрөгийн орлого, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 удаагийн 82,335,742.2 мөнгөний зарлагын гүйлгээ мэдээлэхээс 4 удаагийн 29,201,671.4 мөнгөний төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 58 удаагийн 57,594,863.0 төгрөгийн тушаал шийдвэр мэдээлэхээс 12 удаагийн 14,868,699.0 төгрөгийн шийдвэрийг тус тус мэдээлээгүй.

*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ны өдрийн хүнсний материалын зарцуулалтад аудит хийхэд хоолны өдөрлөг дээр бичигдсэн материалын тоог өсгөн засаж 394,179.0 төгрөгийн материал зарцуулсан.

*Шийдвэрлэсэн нь*:

Анхан шатны баримт засварлан зарцуулсан 394.1 мянган төгрөгийг аймгийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлэх

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2021 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж хөрөнгө худалдаж авсан мөн хүүхдийн тоглоом худалдан авах гэрээний 1.3-д заасны дагуу тоглоом аваагүй, авлага барагдуулж ажиллаагүй зэрэгт 2 албан шаардлага хүргүүлсэн.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **0.0** | | | | |
| Албан шаардлага | 2.0 | 3,863.0 | 2 | 3,863.0 | 100% |
| Зөвлөмж | 3.0 | 0.0 | 1.0 | 0.0 | |
| **Нийт дүн** | **3.0** | **0.0** | **1.0** | **0.0** | |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн бүртгэл хөтлөлт, ашиглалт, хадгалалт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 100.5 мянган төгрөгийн алдаа[1] гарсныг тайлангийн хугацаанд залруулж, ажиллагсдын цалин хөлсийг тогтоохдоо хүний нөөцийн мэдээлэлд үндэслэн, ажилтан орхигдуулалгүй тогтоож олгож байх зөвлөмж өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

5.1.1 Нягтлан бодогч Б.Лхагвадуламд тушаал шийдвэргүй олгосон нэмэгдэл цалин, 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн ээлжийн амралтыг Хөдөлмөрийн тухай хуульд заасан хоногоор тооцож олгон үргэлжлүүлэн жирэмсний амралт эдлүүлэхээр байгууллагын даргын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Б/02 дугаар тушаал гарсан. Байгууллагын эрхлэгчийн Б/23 тоот тушаалаар Б.Лхагвадуламыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс буцаан ажилд авахдаа жирэмсний амралттай байх 6 хоногийн цалинг давхардуулан олгосон, мөн ажиллагсдын ээлжийн амралтын хугацаанд үр дүнгийн урамшуулал тооцож олгосон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид олгох нэмэгдлийг илүү тооцож олгосон зэрэг нийт 918.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6 дугаар зүйлийн 6.4.1.”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/296 тоот тушаалаар батлагдсан "цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:*

Хэтрүүлэн зарцуулсан 918.0 мянган төгрөгийг аймгийн орлого дансанд төвлөрүүлэх, төлбөрийн акт тогтоох

5.1.2 Тайлант оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хүнсний материалын зарцуулалтад түүвэрлэн аудит хийхэд хоолны өдөрлөг дээр бичигдсэн материалын тоог өсгөн засаж 394.1 мянган төгрөгийн материал зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1" Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6."Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:*

Анхан шатны баримт засварлан зарцуулсан материалын үнэ 394.1 мянган төгрөгийг аймгийн орлого дансанд төвлөрүүлэх, төлбөрийн акт тогтоох

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**5.2 Албан шаардлага**

5.2.1 Эрхлэгчийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/59 тоот тушаалаар жилийн эцсийн хөрөнгө тоолох 3 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилогдон тооллого хийсэн гэх боловч анхан шатны баримт материалын бүрдэл дутуу, хөрөнгийн тооллогыг зохих журмын дагуу хийж, үр дүнг тайлагнаж, ажиллаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-д “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;" НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:', 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" гэж заасныг мөрдөж ажиллаагүй.

*Шийдвэрлэсэн нь:*

Хөрөнгийн тооллогыг үнэн зөв, чанартай хийж үр дүнг бүртгэлд тусган биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэх

5.2.2 Тендерт шалгаруулсан худалдан авах ажиллагааны талаарх 1 удаагийн 69,056,500.0 төгрөгийн мэдээ мэдээлэхийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 38 удаагийн 695,530,760.0 төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлэхээс 7 удаагийн 178,686,200.0 төгрөгийн орлого, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10 удаагийн 82,335,742.2 мөнгөний зарлагын гүйлгээ мэдээлэхээс 4 удаагийн 29,201,671.4 мөнгөний төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 58 удаагийн 57,594,863.0 төгрөгийн тушаал шийдвэр мэдээлэхээс 12 удаагийн 14,868,699.0 төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:*

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг иж бүрэн, хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх албан шаардлага хүргүүлэх

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин шинэчлэн тогтоох асуудлаар:

*Илрүүлэлт:* Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122 тоот тушаалын 2-д заасны дагуу 2022 оны 1.2 дугаар сард ТҮБД зэрэглэлийн 5 дугаар шатлалаар цалинжиж байсан багш нарын цалинг тогтоож эрхлэгчийн тушаал гаргалгүй 5 багшийн үндсэн цалинг нэмэгдүүлж олгосон ч туслах багш Б.Оюунцэцэгийн цалинг нэмэгдүүлэлгүй орхисон, Т.Уранбайгальд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллахад олгох нэмэгдлийг тушаалд заасан хувь хэмжээнээс дутуу олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/122 тоот тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/296 тоот тушаалаар батлагдсан "цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар"-ыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

Дутуу олгосон 490.5 мянган төгрөгийн цалинг олгож, цаашид алдааг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шууд зардалд бичсэн | 1 | 100.5 | | | | | 1 | 100.5 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 100.5 | | | | | 1 | 100.5 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалин хөлс илүү тооцож олгосон | 1 | 918.0 | 1 | 918.0 | | | | | | | | |
| Материал илүү зарлагадсан | 1 | 394.1 | 1 | 394.1 | | | | | | | | |
| Хөрөнгийн тооллогыг журмын дагуу хийгээгүй | 1 | 0.0 | | | 1 | 0.0 | | | | | | |
| Дүн | 3 | 1,312.2 | 3 | 1,312.2 | 1 | 0.0 | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 1 | 291,995.0 | | | 1 | 291,995.0 | | |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 291,995.0 | | | 1 | 291,995.0 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

----o0o----